



**2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛС, БҮС, АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ГРАФИК ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нэг. Зорилго

Монгол улсын биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 17.1. дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 467 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхэд өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийг спортын уралдаан тэмцээнд өргөнөөр оролцуулах, авьяасыг нээн илрүүлэх, ур чадвартай тамирчдыг хөгжүүлэх, Монголын Бүх Ард Түмний спортын спартакиад, Монголын хүүхдийн спортын наадам, болон өсвөр залуучуудын уралдаан тэмцээнүүдэд оролцуулахад чиглэгдэнэ.

**Хоёр. Аймгийн аварга шалгаруулах тэмцээний
удирдлага зохион байгуулалт**

Аймгийн бүх ард түмний спортын наадмыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан зохион байгуулах ажлын хэсэг, өсвөр үе залуучуудын аварга шалгаруулах тэмцээнүүдийг Биеийн Тамир, Спортын Газрын даргын тушаалаар байгуулагдсан шүүгчдийн бүрэлдэхүүн удирдан зохион байгуулна.

**Гурав. Аймгийн аварга шалгаруулах тэмцээний
хугацаа, үе шатууд**

Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2026 оны 01 дүгээр сараас 2026 оны 12 сарын 01 хүртэл 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1-р үе шат: Сум, сургууль, байгууллагын хэмжээнд

2-р үе шат: Аймгийн хэмжээнд

Уралдаан тэмцээний задаргаа

№	Спортын төрөл	Ангилал	Хугацаа	Зохион байгуулах газар	Хариуцах эзэн
---	---------------	---------	---------	------------------------	---------------

ӨСВӨР ҮЕИЙН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

1	Самбо бөх	Өсвөр үе	I/23-25	Булган сум	БТСГ
2	Самбо бөх	Сурагчид	I/23-25	Булган сум	БТСГ
3	Пауэрлифтинг	Өсвөр үе, насанд хүрэгчид	I сар	Булган сум	Пауэрлифтингийн холбоо
4	Даам	Өсвөр үе, насанд хүрэгчид	I сар	Булган сум	Даамын холбоо
5	Шатар	Өсвөр үе	I сар	Булган сум	Шатрын холбоо
6	Тэшүүр	Өсвөр үе	II/06-08	Баян-Агт сум	БТСГ, баян-Агт сум ЕБС
7	Модон барилдаан	Өсвөр үе	II/ сар	Булган сум	БТСГ
8	Жудо бөх	Өсвөр үе	III/27-29	Булган сум	БТСГ
9	Сагсан бөмбөг	15-16 нас	IV сар	Булган сум	БТСГ
10	Сагсан бөмбөг 3х3	15 -16 нас	Тусгай заавраар	Булган сум	БТСГ
11	Мини волейбол	8 хүртэл, 10 хүртэл нас	V сар	Гурванбулаг сум	СЗДТГ, ЕБС
12	Мини волейбол	12 хүртэл нас	V сар	Тэшиг сум	СЗДТГ, ЕБС
14	Хөнгөн атлетик	Өсвөр үе	V сар	Булган сум	Хөнгөн атлетикийн холбоо
15	Ширээний теннис	Өсвөр үе	Тусгай заавраар	Булган сум	Ширээний теннис холбоо
16	Буудлага	Өсвөр үе	II/ сард	Булган сум	БХТН
17	Волейбол	Өсвөр үе	Тусгай заавраар	Булган сум	БТСГ, Булган волеболын холбоо

3. НАСАНД ХҮРЭГЧДИЙН УРАЛДААН ТЭМЦЭЭНҮҮД

1	Волейбол	18 наснаас дээш	IV сар	Булган сум	Волейболын холбоо
2	Сагсан бөмбөг	18 наснаас дээш	X сар	Булган сум	БТСГ
3	Дартс	18 наснаас дээш	VI сар	Булган сум	Булган дартс клуб, БТСГ

ҮНДЭСНИЙ СПОРТ

1	Мөсний шагай	18 наснаас дээш	I сар	Булган сум	Мөсний шагайн холбоо
2	Үндэсний сурын харваа	18 наснаас дээш	V сар	Булган сум	Сурын холбоо
3	Үндэсний бөх	18 наснаас дээш	IX сар	Булган сум	БТСГ, үндэсний бөхийн холбоо
4	Үндэсний бөх	16, 17, 18 нас	IX сар	Гурванбулаг сум	СЗДТГ, ЕБС

5	Үндэсний бөх	10,11,12,13,14,15 нас	IV сар	Булган сум	БТСГ
6	Шагайн харваа	Насанд хүрэгчид	Тусгай заавраар	Булган сум	Шагайн холбоо
УЛС, БҮС, ОЛОН ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН					
1	Анхдагчдын цом олон хотын цанын тэмцээн	Өсвөр үе, насанд хүрэгчид	I / 14-16	Тэшиг сум	СЗДТГ, Хилийн цэргийн 0286-р анги, ЕБС
2	Даам бүсийн тэмцээн	Насанд хүрэгчид	VI/13-14	Булган сум	Булган аймгийн даамын холбоо
3	Жудо бөх бүсийн тэмцээн	Өсвөр үе	III сар	Булган сум	БТСГ, Жудо бөхийн холбоо

ТЭМЦЭЭНИЙ ТОДОТГОЛУУД:

Тэмцээний насны ангилал: Аймгийн аварга шалгаруулах тэмцээний насны ангиллыг Засгийн газрын тохируулагч агентлаг БТСУХорооны 2026 оны спортын уралдаан тэмцээний нэгдсэн төлөвлөгөө, Спортын холбоодын заавруудыг үндэслэн гаргасан болно. Насанд хүрэгчдийн уралдаан тэмцээнд 19 нас хүрсэн буюу түүнээс дээш насны тамирчдыг оролцуулах бөгөөд өсвөрийн тамирчдыг оролцуулахгүй болно. Ахмадын тэмцээний насыг спорт холбоодын саналыг үндэслэн тогтооно.

Тэмцээнд зөрчил гарсан тохиолдолд: Өсвөрийн баг тамирчдын тэмцээн уралдаанд хүүхдийн нас дарсан, бичиг баримтын зөрчил гаргасан багш дасгалжуулагчидтай хариуцлага тооцох бөгөөд тамирчныг хасах, багаар нь хасах, багш нарын тамирчдыг дасгалжуулан тэмцээн уралдаанд орох эрхийг хасах хүртэл арга хэмжээ авах болохыг анхааруулж байна.

Мөн спортын бус бүдүүлэг алдаа гаргасан тамирчдад дээрхи хариуцлагын арга хэмжээ авна.

Тэмцээнд оролцох тамирчдын хувийн ариун цэврийг сахих, спортын төрлийн онцлогоос шалтгаалах бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх зааварчилгааг өгсөн байна.

Тамирчин дасгалжуулагчдын мандатын талаар: Олон улсын болон Монголын спортын холбоодуудын жишгийн дагуу тэмцээн уралдаанд оролцож байгаа өсвөрийн тамирчин мандатын буюу тэмцээнд оролцох хураамж тухайн төрөлд заасан заавар удирдамжын дагуу хураамжийг төлж оролцоно.

Тав. Тэмцээний бичиг баримт бүрдүүлэлт, мэдүүлэг хүлээн авах журам

Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлэгийг тэмцээнд эхлэхээс 2 хоногийн өмнөөс авч эхэлнэ. Мэдүүлгийг тухайн сумын Засаг дарга, сургуулийн захирал, байгууллагын даргын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан эмчийн үзлэгээр хамрагдсан тодорхойлолт зэргийг авч ирнэ. Мандатыг багуудад нэгдсэн журмаар олгох бөгөөд мандат авахад доорхи бичиг баримтуудыг бүрдүүлэн оролцоно. Үүнд:

1. Төрсний гэрчилгээ
2. Сурагчийн хувийн хэрэг
3. Иргэний үнэмлэх
4. Зураг \4х3\ 2%
5. Эмчийн тодорхойлолт \тамирчин нэг бүр дээр\
6. Гадаад паспорт

Зургаа: Шагнал урамшуулал

Аймгийн аварга шалгаруулах тэмцээний шагналыг зохион байгуулж байгаа газрууд хариуцах бөгөөд тамирчдын ирж очих унаа, байр хоолны зардлыг тамирчдаа оролцуулж байгаа сум, байгууллага хариуцана.

СПОРТЫН ХЭЛТЭС